

ЧЕХ УЛС ДАХЬ ҮНДСЭН БОЛОВСРОЛ

Онцлог шинж чанарууд

Чех Улсад суурь боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол ба гэр бүл дэх хүмүүжлийг залгамжладаг. Сургалтын хөтөлбөрийн баримт бичгийн систем нь хоёр түвшинтэй байдаг – улсын ба сургуулийн. Ерөнхий боловсролын программ улсын түвшинд дагаж мөрдөх боловсролын хүрээг тодорхойлдог. Энэ ерөнхий боловсролын хүрээнд үндэслэн сургуулиуд өөрсдийн сургуулийн боловсролын хөтөлбөрүүдийг (СБХ) зохион байгуулдаг.

Зорилго

- сурагчдад сургалтын стратегид сурах боломж олгох ба насан туршийн боловсрол эзэмших тухай сэдэл төрүүлэх;
- сурагчдыг бүтээлч сэтгэлгээ, логик бодол ба асуудлыг шийдвэрлэхэд уриалах;
- сурагчдыг цогц, үр дүнтэй ба нээлттэй харилцаанд хөтлөх;
- сурагчдын хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх, өөрийн болон бусдын хөдөлмөр ба ололт амжилтыг хүндэтгэх;
- сурагчдыг өөрсдийгөө бие даасан, чөлөөтэй ба хариуцлагатай хувь хүн болгож харуулах, эрхээ эдлэх ба үүргээ биелүүлэхэд бэлтгэх;
- сурагчдыг зан байдал, үйл хөдлөл ба амьдралын нөхцөл байдалд эерэг мэдрэмжтэй болгохыг сургах; хүмүүс, хүрээлэн буй орчин ба байгальтай харьцахдаа мэдрэмжтэй харилцаа хөгжүүлэх;
- сурагчдыг өөрийнхөө бие бялдар, оюун санаа ба нийгмийн эрүүл мэндийг идэвхтэй хөгжүүлэх, хамгаалах ба хариуцлагатай байхыг сургах;
- сурагчдыг бусад хүмүүст, тэдний соёл, оюун санааны үнэт зүйлсийн талаар хүлцэнгүй хандах, тэдэнд анхаарал хандуулах ба бусад хүмүүстэй хамт амьдрахыг сургах;
- бодит нөхцлийн дагуу сурагчдад өөрсдийн чадвараа таньж, хөгжүүлэхэд нь туслах, олж авсан мэдлэг ба ур чадвараа өөрийн амьдрал ба мэргэжлийн чиг баримжааны талаар шийдэхэд нь туслах;
- сурагчдад дижитал орчныг танин мэдэхэд туслах, ажил дээр, сурахад, чөлөөт цагаа өнгөрөөхөд, нийгэм ба иргэний амьдралд оролцоход дижитал технологийг аюулгүй, итгэлтэй, шүүмжлэлтэй ба бүтээлчээр ашиглахад нь тусламж үзүүлэх:.

Суурь боловсролын зохион байгуулалт

Хичээлийн жил 9-р сарын 1-нд эхлэх бөгөөд дараа жилийн хуанлийн 8-р сарын 31-нд хүртэл бүтэн сургуулийн жилд үргэлжилнэ.
Зуны амралт 7-р сарын 1-ээс 8-р сарын 31-нд хүртэл үргэлжилнэ.

6-7 насандаа хүүхдүүд бага сургуульд орж, тэд нар сургуульд **заавал эзэмших боловсролд** хамаарагддаг. Сургуульд заавал эзэмших боловсрол нь 9 жил үргэлжилдэг бөгөөд бүх хүүхдүүдэд, түүний дотор Чех Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэдэд ч гэсэн хамаардаг. **Заавал эзэмших сургуулийн боловсрол нь хүүхдийн зургаан нас хүрсэн өдрөөс хойшхи хичээлийн жилийн эхнээс эхлэх болно, хэрэв түүнд хойшлуулалт зөвшөөрөгдөөгүй бол сургуульд орох болно.**

Хууль ёсны төлөөлөгч нь хүүхдийг **заавал эзэмших боловсролын элсэлтэнд бүртгүүлэх** үүрэгтэй, тэгэхдээ хүүхэд нь заавал сургуульд явж эхлэх ёстой хуанлийн жилийн **4-р сарын 1-нээс 4-р сарын 30-ны хооронд** хүүхдийг заавал сургуульд бүртгэх үүрэгтэй.

Хүүхдийг бага сургуульд элсүүлэх нь хуулийг даган мөрдөж байгаа учраас сурагчийн оршин сууж буй газраас нөлөөлж, сургууль нь тодорхойлогдоно (хамаарагдах сургууль - хүүхдийн оршин сууж байгаа хаягаар нь хамаарагдах сургууль болно). Хүүхдийг сургуульд оруулахаас татгалзаж болохгүй, гэвч сургуулийн хүүхдийн орон тоо дүүрсэн гэдэг шалтгаан байж болно. Хэрэв хүүхдийн орон тоо дүүрсэн гэдэг шалтгаан тохиолдвол, тухайн тосгоны эсвэл хотын захиргаалны боловсролын хэлтэст хандах хэрэгтэй. Гадаадын иргэний хүүхдийг Чех хэл мэдэхгүй учраас түүнийг сургуульд авахгүй гэж хэлж болохгүй. Хүүхдийг хамаарагдах сургуулиас гадуур өөр сургуульд оруулж болдог, тэгэхдээ тухайн сургуулийн хүүхдийн орон тооны багтаамжаас ба сургуульд орох шалгууруудыг биелүүлснээс нөлөөлдөг.

Хэрэв хүүхэд 1-р ангид ороход хангалттай бэлтгэлгүй бол **сургуулийн заавал эзэмших боловсролын хойшлуулалт** гэж нэртэй өргөдөл гаргаж болдог эсвэл түүнийг **бэлтгэл ангид** оруулж болно. Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь бүртгэлд ирэхдээ заавал эзэмших боловсролыг хойшлуулах тухай шаардана. Сургуулийн захиралд өргөдлийг бичгээр ирүүлдэг бөгөөд сургуулийн зөвлөгөө өгдөг байгууллагаас авсан тодорхойлолттой байх ёстой (эцэг эх нь хүүхэдтэй хамт захиалга өгч тэнд очдог, сургуулийн зөвлөгөө өгдөг байгууллагыг сонгож болно), түүнээс гадна мэргэжлийн эмч ба клиник сэтгэл зүйчээс тодорхойлолт хэрэгтэй (хүүхэд ба өсвөр насны өрхийн эмчээс авсан зөвлөмж нь хангалттай байдаг). Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь заавал эзэмших боловсролын хугацааг хойшлуулах тухай шаардах гэвэл, хүүхдийн сургуульд явах ёстой хуанлийн жилийн 5-р сарын 31-ний дотор өргөдөл гаргах ёстой.

Чех Улсад **боловсролын тусгай хэрэгцээтэй** сурагчдад зориулсан **тусгай боловсролын систем** байдаг (жишээлбэл, сэтгэцийн, харааны, сонсголын болон ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан). Хэдий ч гэсэн ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчдын боловсролыг давуу талтай гэж үздэг. Хүүхдийг тусгай сургуульд байрлуулах тохиолдол гарвал эмч ба зөвлөгөө өгөх байгууллагаас баталгаажуулах ёстой бөгөөд зөвхөн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийн дагуу ийм үйлдэл хийж болно. Чех хэлний хангалтгүй мэдлэг нь тусгай боловсролын системд хамрагдах шалтгаан биш юм.

БАГА СУРГУУЛЬ

Бага сургуульд ихэвчлэн 6-15 насны сурагчид хамрагддаг. Бага сургууль нь хоёр үе шаттай бөгөөд эхний үе шат нь таван ангитай (1-р - 5-р анги хүртэл), хоёр дахь үе шат нь дөрвөн ангитай (6-р – 9-р анги хүртэл) байдаг. Зарим сурагчид бага сургуулийн эхний үе шатыг дууссаны дараа олон жилийн сургалттай гимназид шилждэг.

Улсын бага сургуулийн боловсрол нь үнэ төлбөргүй байдаг. Заавал эзэмших боловсролтой сурагчид нь сурах бичиг ба сурах номуудыг үнэ төлбөргүйгээр зээлдэж авах эрхтэй. Эцэг эхчүүд нь сурагчдын хувийн хэрэгцээ, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, хичээлээс гадуур явагдах курс, хоол, сургуулийн хичээлийн бус цагийн бүлгэм гэх мэтийн ажилд санхүүгийн талаас нь хувь нэмэр оруулдаг.

Сургууль бүр **Сургуулийн дүрэмтэй** байдаг, энэ нь сургуулийн дотоод амьдралыг зохицуулдаг баримт бичиг болно. Энэ нь бүх сурагчид, тэдний хууль ёсны төлөөлөгчид, ажилтнууд болон сургуулийн гадна болон дотор зохион байгуулж байгаа сургуулийн арга хэмжээнд оролцогчдын хувьд хүчинтэй бөгөөд заавал дагаж мөрдөгдөх ёстой.

Хичээлийн жилийн хуваарь

Хичээлийн жил нь 9-р сарын 1-нд эхлэж дараагийн хуанлийн жилийн 8-р сарын 31-нд дуусдаг. Хичээлийн жил нь хоёр улиралтай: 1-р улирал (9-р сарын 1-ээс 1-р сарын 30), 2-р улирал (2-р сарын 1-ээс 8-р сарын 31). Зуны үед: долдугаар сар ба наймдугаар сард сурагчид хичээлдээ явахгүй бөгөөд хоёр сарын хугацаагаар **зуны амралттай** (7-р сарын 1-ээс 8-р сарын 31-ний хооронд).

Дараагийн амралтууд:

- намрын гурван өдрийн амралт - 10-р сарын 28-ны орчим.
- Зул сарын баярын өдрүүд - ихэвчлэн 12-р сарын 23-аас 1-р сарын 2 хүртэл.
- хагас жилийн нэг өдрийн амралт - ойролцоогоор 2-р сарын 1-ний орчим.
- хаврын амралт – 2-р эсвэл 3-р сард долоо хоног, огноо жил бүр өөрчлөгддөг
- Улаан өндөгний баярын өдрүүд - Ногоон Пүрэв гараг, Их Баасан гараг ба Улаан өндөгний баярын Даваа гараг.

Сурагчид **улсын баярын өдрүүдэд** сургуульдаа явдаггүй:

- 9-р сарын 28-нд, Чех Улсын баярын өдөр
- 10-р сарын 28-нд, Чехословак Улсын тусгаар тогтнолын баярын өдөр
- 11-р сарын 17-нд, Эрх чөлөө ба ардчиллын төлөө тэмцэх өдөр
- 5-р сарын 1-нд, Хөдөлмөрийн баярын өдөр
- 5-р сарын 8-нд, Ялалтын баярын өдөр

Сургалтын одоогийн цагийн хуваарийг сургуулийн вэб-сайтаас авах боломжтой.

Үнэлгээ ба гэрчилгээ

Багш нар сурагчдын боловсролын үр дүнг **тэмдэг ашиглан** үнэлдэг. Эдгээр нь 1-ээс 5 хүртэл хувиартай бөгөөд 1 нь хамгийн сайн үр дүн, 5 нь хамгийн муу үр дүн болдог юм. Зарим сургуулиуд **аман үнэлгээ** эсвэл аман үнэлгээ болон тоон үнэлгээг хослуулан хэрэглэдэг. Үнэлгээг **сурагчийн дэвтэрт** (цаасан эсвэл цахим хэлбэрээр бичиж болно). Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь сургуулийн вэб-сайтад нэвтэрсний дараа сурагчийн тэмдэгтэй танилцах боломжтой, өөр хэн ч энэ тэмдгийг үзэх боломжгүй.

Гэрчилгээ нь оюутны өнгөрсөн хагас жилд бие даасан хичээлүүдийн нийт үнэлгээ болдог, түүний дотор бас сахилга батын үнэлгээ байдаг. Хүүхдүүд жилд хоёр удаа гэрчилгээ авдаг. Бага сургуулийн хоёрдугаар үе шатанд гэрчилгээнд хувь хүний тэмдгийг үгээр тайлбарлаж хэлдэг, үүнд:

- 1 - онц сайн,
- 2 - сайшаалтай,
- 3 - сайн,
- 4 - хангалттай,
- 5 - хангалтгүй.

Гэрчилгээнд 1, 2, 3, 4 гэсэн тэмдгүүд нь тухайн сурагч тухайн хичээлийн жилд **тэнцсэн** гэсэн утгатай болно. 5 гэсэн тэмдэг нь түүнийг **тэнцээгүй** гэсэн үг юм. Хэрэв сурагч хоёрдугаар улирлын төгсгөлд хичээлдээ тэнцээгүй бол дахин **засварын шалгалт** өгөх боломжтой. Хэрэв тэр шалгалтаа өгч чадахгүй бол тэр **жилээ давтах ёстой**.

Цагийн хуваарь

Сурагчид долоо хоногт Даваа гарагаас Баасан гараг хүртэл хичээллэдэг. Тэд хагас сайн ба бүтэн сайн өдөрт хичээлдээ явдаггүй. Нэг **хичээлийн цаг** 45 минут үргэлжилдэг бөгөөд дараа нь 10-20 минутын завсарлагаа хийдэг. Нэгдүгээр ба хоёрдугаар жилд сурагчид долоо хоногт 18-22 хичээлийн цагтай, гурав дахиа тав дугаар жилд долоо хоногт 22-26 цаг хичээллэдэг. Хоёр дахь үе шатанд долоо хоногт ажиллах цагийн тоо 28-32 хичээлийн цаг болж нэмэгдэдэг.

Хичээлийн өдөр ихэвчлэн өглөөний 8.00 цагт эхэлдэг бөгөөд сургуулийн өдрийн үргэлжлэх хугацаа нь тухайн өдөрт сурагчийн хичээлийн цагаас хамаардаг. Энэ нь сурагчийн хичээлийн жилийн эхэнд авсан **хичээлийн цагийн хуваариар** тодорхойлогддог бөгөөд сургуулийн вэб-сайт дээр тавигддаг. Сурагчид бол хичээлийн хуваарийг заавал дагаж мөрдөх ёстой бөгөөд заасан бүх хичээлд оролцох үүрэгтэй. 1-р үе шатны сурагчид нь 12 цагт, 2-р үе шатны сурагчид нь 13-15 цагийн хооронд хичээлээ төгсдөг.

Суралцах хичээлүүд

1-р үе шат:

- **чех хэл:** сурагчид уншиж ба бичиж сурна, хэл зүй ба уран зохиолын талаар суралцана,
- **гадаад хэл:** (хамгийн сүүлд 3-р ангиас) ихэвчлэн англи хэл,
- **математик:** тоо, тооны үйлдэл, геометрийн үндэс,
- **мэдээлэл зүй:** мэдээлэл зүйн сэтгэлгээг хөгжүүлэх,
- **нийгмийн ухаан** (1-3-р анги): бидний амьдардаг газар, нийгэм, байгаль, эрүүл аж амьдрал,
- **байгалийн ухаан** (4-5-р анги): байгаль ухааны чиглэлээр нийгмийн ухааны хичээлийг залгамжлах,
- **эх орон судлал** (4-5-р анги): түүх, газар зүйн чиглэлээр нийгмийн ухаан дээр тулгуурладаг,
- **хөгжмийн боловсрол:** сурагчид хөгжмийг ойлгож, тайлбарлаж, бүтээж сурах,
- **урлагийн боловсрол:** сурагчид дүрслэх урлагийг ойлгох, тайлбарлах, бүтээж суралцдаг,
- **биеийн тамир:** сурагчид нь хөдөлгөөний чадварыг эзэмшдэг,
- **хөдөлмөрийн үйл ажиллагаа:** сурагчид практик ажлын ур чадвар эзэмшдэг.

2-р үе шат:

- **чех хэл:** унших, текст бичих, уран зохиолын хэл ба уран зохиол,
- **гадаад хэл:** сурагчид A2 түвшинд гадаад хэлний мэдлэгтэй болох,
- **математик:** тоо бодлогын үйлдэл, хамаарал, геометр,
- **мэдээлэл зүй:** мэдээлэл зүйн сэтгэхүй, дижитал технологийн зарчмууд
- **түүх:** Чех Улсын ба дэлхийн түүх,
- **иргэний боловсрол:** нийгэм, улс төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагаа,
- **физик:** бодисын шинж чанарууд, биеийн хөдөлгөөн, эрчим хүч, дуу авиан, цахилгаан,
- **хими:** бодис, органик ба органик бус нэгдлүүдийн найрлага, тэдгээрийн урвал,
- **байгалийн түүх:** байгаль, ерөнхий биологи ба экологи,
- **газарзүй:** дэлхийн бүс нутаг – Чех Улсын нийгмийн ба эдийн засгийн орчин, газарзүй,
- **хөгжмийн боловсрол:** сурагчид хөгжмийг ойлгох, тайлбарлах, бүтээж сурах,
- **урлагийн боловсрол:** сурагчид дүрслэх урлагийг ойлгох, тайлбарлах, бүтээж суралцдаг,

- **биеийн тамир:** хүүхдүүд хөдөлгөөний чадвар эзэмшдэг,
- **хөдөлмөрийн үйл ажиллагаа:** сурагчид практик ажлын ур чадвар эзэмшдэг.

Сургуульд хооллох

Өглөөний хичээлийн туршид сурагчдын гэрээс авчирдаг зууш идэхэд зориулсан урт хугацааны завсарлагаа байдаг. Сурагчид **сургуулийн гуанзанд** өдөр бүр үдийн хоол идэх боломжтой. Ихэнхдээ хэд хэдэн хоолны сонголт байдаг бөгөөд нэг нь махгүй хоол байдаг. Сурагчид үдийн хоолоо хичээлийн дараа эсвэл үдийн завсарлагааны үед идэх боломжтой (хамгийн багадаа 30 минут болдог). **Хууль ёсны төлөөлөгчид нь сургуулийн үдийн хоолыг төлөх ёстой** бөгөөд хоолны үнэ нь улсаас татаастай учраас харьцангуй бага байдаг. Нэг үдийн хоолны үнэ нь 20-30 Чех кроны төлбөртэй байдаг.

Сургуулийн хичээлийн бус цагийн бүлгэм

Бага сургуулиуд сурагчдад хичээл эхлэхээс өмнө өглөө 6.30 цагаас эхлэж, мөн хичээл тарсны дараа ихэвчлэн 16-17 цагийн хооронд сургуулийн хичээлийн бус цагийн бүлгэмд байлгахыг санал болгодог. Сурагчид нь энэ бүлгэмд сурган хүмүүжүүлэгч нарын удирдлага дор хобби, янз бүрийн тоглоом, урлаг, спортын үйл ажиллагаа ба амралт зэрэг үйл ажиллагаа эрхэлдэг. Сурагчийн сургуулийн бүлгэмд байх төлбөрийг **эцэг эх нь төлөх ёстой** бөгөөд үнэ нь сард 100-250 Чех кроны төлбөртэй байдаг.

Чөлөөт цагийн үйл ажиллагаа

Олон сургуулиуд хичээлийн дараа сургуулийн бүлгэмийн хүрээнд, бас гадуур ч гэсэн, янз бүрийн арга хэмжээг сурагчдад санал болгодог. Энэ чөлөөт цагийн үйл ажиллагаа (**дугуйлан** гэж нэртэй) нь сурагчдад шинэ ур чадвар эзэмших, найз нөхөдтэй болох, чех хэлээр дадлага хийх боломжийг олгодог.

Үйл ажиллагааны цар хүрээг сургуулийн вэб-сайтаас авах боломжтой бөгөөд ихэвчлэн дараахь зүйлийг агуулдаг:

- хөгжмийн дугуйлан: лимбэ тоглох, найрал дуу дуулах гэх мэт.
- уран сайхны үйл ажиллагаа: ваар эдлэл, зураг зурах, гэрэл зураг, драмын дугуйлан,
- спортын үйл ажиллагаа: аэробик дасгал, бөмбөг тоглоом, хөнгөн атлетик, хөл бөмбөг, тулааны урлаг гэх мэт.
- хэлний курсууд,
- компьютерийн дугуйлан.

Зарим сургуулиуд чөлөөт цагийн үйл ажиллагаа үнэ төлбөргүй явуулдаг боловч ихэнх нь төлбөр шаардадаг. Нэг хагас жилийн үнэ төлбөр нь 100-500 кроны хооронд хэлбэлздэг.

Сургуультай харилцах

Сурагч бүр **сурагчийн дэвтэр** буюу **тэмдэглэлийн дэвтэр** (1,2-р ангид) авах бөгөөд үүнд үнэлгээ тэмдэглэдэг ба сургуультай харилцдаг. Энэ мэдээлэл нь сургалтын хүрээнд ер бусын үйл ажиллагаа (аялал, хот явах, гэх мэт) эсвэл сурагчийн сургууль дээрх зан авиртай холбоотой тэмдэглэл байж болно. Ихэнх сургуулиуд нь **сурагчийн цахим ном** гэгчийг ашигладаг юм. Энэ нь сургуулийн вэб-сайт дээр байдаг бөгөөд эцэг эхчүүд нь хүүхдийнхээ бүх тэмдгүүд, түүнчлэн сургуулийн бүх зар зарлалыг эндээс олж авах боломжтой.

Сурагчийн дэвтэрт нь **уучлалын хуудас** гэж нэртэй тэмдэглэл байдаг бөгөөд хууль ёсны төлөөлөгчид нь хүүхдийг хичээлдээ ирэхгүйд уучлалт гуйх үүрэгтэй.

Сургууль нь жилд хоёроос доошгүй удаа **ангиудын уулзалт** зохион байгуулдаг бөгөөд эцэг эхчүүд нь багш нартай уулзаж, сурагч нь сургууль дээрээ ямар байдалтай байгааг олж мэддэг, багш нарт янз бүрийн асуулт тавих боломжтой. Сургууль нь ангиудын уулзалтын товыг тэмдэглэлийн дэвтэрт эсвэл сурагчийн дэвтэрт бичиж мэдүүлдэг, бас интернетээр дамжуулан мэдээлдэг.

Мөн ангийн багштай эсвэл бусад багштай хувийн уулзалт зохион байгуулах боломжтой. Ихэнх сургуулиуд нь багш нарын **зөвлөлдөх цагийг** санал болгодог эсвэл шаардлагатай байвал уулзалтыг тус тусад нь зохион байгуулж болдог.

Эрх ба үүрэг

Сурагчид дараахь эрхтэй:

- боловсрол ба сургуулийн үйлчилгээ,
- боловсролын явц ба үр дүнгийн талаархи мэдээлэл,
- боловсролын чухал асуудлуудтай холбоотой бүх шийдвэрт тайлбар өгөх, тэгэхдээ хүүхдийн нас ба хөгжлийн түвшинд анхаарлаа хандуулах ёстой,
- боловсролтой холбоотой асуудлаар сургууль эсвэл сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагаас мэдээлэл, зөвлөгөө авах.

Насанд хүрээгүй сурагчдын хууль ёсны төлөөлөгчид дараахь эрхтэй:

- насанд хүрээгүй хүүхдийн боловсролын явц, үр дүнгийн талаархи мэдээлэл,
- сургуулийн зөвлөлд санал өгөх ба сонгогдох,
- насанд хүрээгүй сурагчдын боловсролтой холбоотой асуудлын талаархи бүх шийдвэрт тайлбар өгөх,
- боловсролтой холбоотой асуудлаар сургууль ба сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагаас мэдээлэл, зөвлөгөө авах.

Сурагчид нь үүрэгтэй:

- сургууль, сургуулийн байранд зохих аргаар хүрч ирээд, зүй ёсоор хүмүүжүүлэх ба боловсруулах

- сургуулийн дотоод журам, дүрэм, сургуулийн ба сургуулийн барилга байгууламжийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хамгаалах зааврыг дагаж мөрдөх,
- хууль эрх зүйн зохицуулалтын дагуу, сургуулийн болон дотоод журмын дагуу гаргасан сургуулийн ба сургуулийн барилга байгууламжийн сурган хүмүүжүүлэх ажилтнуудын заавруудыг дагаж мөрдөх.

Насанд хүрээгүй сурагчдын хууль ёсны төлөөлөгчид үүрэгтэй:

- сурагч нь сургууль, сургуулийн байранд зохих ёсоор хамрагдан хүрч ирэх,
- сургуулийн болон сургуулийн захирлын урилгаар сурагчийн боловсролтой холбоотой чухал асуудлуудыг хэлэлцэхэд биечлэн оролцох,
- эрүүл мэндийн байдал өөрчлөгдсөн тухай, сурагчийн эрүүл мэндийн хүндрэл болон боловсролын явцад нөлөөлж болох бусад ноцтой бодит байдлын талаар сургууль ба сургуулийн байгууламжинд мэдээлэл өгөх,
- сурагч хичээлд ирэхгүй шалтгааныг сургуулийн дүрэмд заасан нөхцлийн дагуу мэдээлэл өгч батлах,
- боловсролын явцад эсвэл сурагчийн аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, энэ мэдээллийн өөрчлөлтийг сургууль ба сургуулийн барилга байгууламжид хүргэж өгөх.

Эх сурвалж

- Хуулийн эмхтгэлийн 561/2004 тоот хууль, Сургуулийн өмнөх, бага, дунд, дээд мэргэжлийн болон бусад боловсролын тухай (Сургуулийн тухай хууль).
- Суурь боловсролын Ерөнхий боловсролын хөтөлбөр.